

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Нэг. Ерөнхий зүйл

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлав.

Хуулийн төсөл нь уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг дэмжих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэхтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тооцсон болно.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг тандан судлах явцад тус тус гүйцэтгэнэ.

Энэ нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой.

Хоёр. Иргэн, хуулийн этгээд, хувь хүнд үүсгэх зардал

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл дэх зохицуулалтууд нь иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэхгүй. Биржийг байгуулахтай холбоотой дараах зардал гарна. Үүнд:

Биржийн байгуулахад гарах зардал

#	Зардлын төрөл	Дүн, сая ам.доллар	Тэрбум төгрөг
1	Биржийн программ хангамж худалдан авалт, суурилуулалт, ашиглалтын зардал	8.5	24.2
		8.5	24.2

Биржийн үйл ажиллагааны зардал (жилд)

#	Зардлын төрөл	Ажилтны тоо	Дүн, тэрбум төгрөг
1	Цалин	20	0.72
2	НДШимтгэл	12 сар	0.09
3	Сургалт судалгаа		0.12
	Дүн		0.93

Тайлбар: биржийн арилжаанаас олох орлогоор үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлнэ. Улсын төсвөөс хөрөнгө гарахгүй.

Гурав. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар бий болно гэж үзэж байна. Үүнд:

- ✓ Монгол Улсад уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах эрх зүйн орчин бүрдэж, улмаар уул уурхайн бүтээгдэхүүний нийлүүлэгч, худалдан авагчийг холбох найдвартай тогтолцоо бий болж, зах зээлийн бодитой ханш тогтох, арилжааны болон гэрээ, хэлцлийн мэдээлэл олон улсын зах зээлд нээлттэй зарлагдсанаар хөрөнгө оруулагчид найдвартай мэдээллээр хангагдах, улмаар Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нэмэгдэх юм.
- ✓ Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, борлуулалтын хэмжээ ил тод болсноор арилжаанаас тооцох татвар хураамжийг үндэслэлтэй тогтоох нөхцөл бүрдэж улсын төсвийн орлого нэмэгдэнэ. Мөн уул уурхайн бүтээгдэхүүнийг нийлүүлэх гэрээний үүргийн хэрэгжилт баталгаатай болж арилжаанд оролцогчдын эрсдэл буурах, хөрөнгө оруулалтын таатай орчин бий болох ач холбогдолтой юм.
- ✓ Уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулагдсанаар биржийн арилжааны төлбөр тооцоо Монгол Улсын банк санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж, гадаад валютын орлого нэмэгдэж, ханш тогтворжих, таатай нөхцөл бүрдэнэ.
- ✓ Түүнчлэн уул уурхайн бүтээгдэхүүний чанар олон улсын стандартын түвшинд хүрч сайжрах бөгөөд үүнийг дагаад техник, технологийн шинэчлэл хийгдэх, шинээр ажлын байр бий болох нөхцөл бүрдэнэ. Мөн биржийг дагалдан арилжааны зуучлагч, тээвэр логистик, баталгаат агуулах, даатгал зэрэг цогц үйлчилгээ бий болох юм. Энэ нь уул уурхайн бүтээгдэхүүний зохион байгуулалттай зах зээлийн найдвартай, тогтвортой ажиллагааг дэмжихийн зэрэгцээ татварын суурийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.
- ✓ Нөгөө талаас биржийн арилжааг амжилттай явуулах зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүний гарал үүсэл, ангилал, кодчилал, чанарын шаардлага зэргийг нарийн тогтоох, улмаар биржийн ажиллагааг хангах техник, технологи, хүний нөөцийн чадавхийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Энэ хууль батлагдсанаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг хавсралтаар гаргав.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР